

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт,
үр дүн, үр ашиг

АУДИТЫН КОД: ТӨА-2022/16-18-ШТА-ТД

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn
Аудитор Ч.Загдсүрэн
Утас: 70272287 Цахим хаяг: zagdsurench@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёог.....	2
Хавсралтын товъёог.....	3
Товчилсон үгийн тайлбар.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
А.1 “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар цахим удирдлагын системд орж, үнэлж, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээнүүд батлагджээ.....	7
А.2. Зөвлөх үйлчилгээ гэрээгээр гүйцэтгэгч компаниуд нь гэрээний хугацаанд ажлаа дуусгаж хүлээлгэж өгөөгүйгээс батлагдсан зураг, төсөвгүй барилга байгууламж баригдаж байна.....	8
А.3. Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалт нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.....	11
А.4. Батлагдсан зураг, төсөвгүй ажлыг ажлын тоо хэмжээгээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж, үнэлгээний хороо нь ТББ-ийн шалгуур хангаагүй оролцогчид гэрээ байгуулах эрх олгожээ.....	14
Б. “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар зураг, төсөвгүй ажил батлагдаж хэрэгжсэнээс зарим ажлын санхүүжилт дутуу батлагдаж, хуулийн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй болжээ.....	19
Б.1 Батлагдсан зураг, төсөвгүй ажилд ХАА зохион байгуулж, гэрээ байгуулснаар зарим барилга, хөрөнгө оруулалт дутуу хийгдэж, хуулийн хугацаанд ашиглалтад орох боломжгүй болсон байна.....	19
Б.2 Улсын төсвөөс нийт 48,984.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 10 ажлын 4,828.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 44,121.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ.....	24
Б.3 Төв аймаг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ажлыг гэрээгээр гүйцэтгэгч нарт барьцаа хөрөнгө болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгоогүй, ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгосон байна.....	26
ДҮГНЭЛТ:.....	28
ЗӨВЛӨМЖ:.....	29
Холбогдох байгууллагын санал:.....	32

Хүснэгтийн товъёог

Хүснэгт 1: Аймгийн ТЕЗ-аас хэрэгжүүлэхээр явуулсан төсөл, арга хэмжээний саналын судалгаа.....	7
Хүснэгт 2: 2021 оны Монгол улсын төсвийн тухай хуулиар батлагдсан ХО-ын судалгаа ТЕЗ-аар.....	8
Хүснэгт 3: Эрх шилжсэн хөрөнгө оруулалт зардлын төрлөөр.....	9
Хүснэгт 4: Төв аймагт 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ХО-ын судалгаа.....	20
Хүснэгт 5: 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжсэн ХО-ын зураг, төсвийн судалгаа.....	21
Хүснэгт 6: 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ХО-д хийсэн хяналтын зардлын судалгаа.....	24
Хүснэгт 7: 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ХО-ын санхүүжилт, гүйцэтгэлийг харьцуулсан судалгаа.....	25
Хүснэгт 8: 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ХО-ын санхүүжилт, гүйцэтгэлийн зөрчлийн судалгаа.....	26

Хавсралтын товъёог

Хавсралт 1: Шинээр батлагдсан ХО-ын хэрэгцээ, шаардлагын судалгаа.....	30
Хавсралт 2: 2021 оны Төсвийн тухай хууль, МЕД-ээр баталгаажсан төсөвт өртгийн зөрүү тооцсон судалгаа	31

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗЗА	Авто зам засвар, арчлалт
БЗОСК	Барилга захиалагч, орон сууц корпорац
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
БХТ	Барилгын хөгжлийн төв
БХБ	Барилга, хот байгуулалт
БХБХ	Барилга, хот байгуулалтын хэлтэс
БОАЖ	Байгаль орчин, аялал жуулчлал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХ	Зам, тээвэр хөгжил
ЗТХЯ	Зам, тээвэр хөгжлийн яам
ЗТХТ	Зам, тээвэр хөгжлийн төв
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗЗБНБД	Зам, замын байгууламжийн норм ба дүрэм
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
МЕД	Магадлалын ерөнхий дүгнэлт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТББ	Тендерийн баримт бичиг
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТБОНӨХБАУХАА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа
ТОӨЗ	Тендерт оролцогчид өгөх зөвлөмж
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТШМ	Тендер шалгаруулалтын материал
УИХ	Улсын Их Хурал
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ХОХБТ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ЭШХО	Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд санхүүжүүлэхээр баталсан 31 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын хязгаарлалт

Байхгүй.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Барилга, байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт
- Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн нар гүйцэтгэв.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдөр эхэлж, 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэн, ҮАГ-т судалгаа, тайланг хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл

А. “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй, батлагдсан зураг, төсөвгүй хөрөнгө оруулалтын ажлууд батлагдсан байна.

А.1 “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар цахим удирдлагын системд орж, үнэлж, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээнүүд батлагджээ.

Аймгийн Засаг даргаас 2021 онд 11 ТЕЗ-д 206,322.8 сая төгрөгийн нийт 73 хөрөнгө оруулалтын ажлыг шинээр хэрэгжүүлэх саналыг “Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын систем”-д оруулж хүргүүлсэн байна.

“Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар Төв аймагт 8 ТЕЗ-аас 41,865.8 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжихээр жагсаалтаар батлагджээ. Батлагдсан төсөл арга хэмжээний 14,561.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын саналд үндэслэж, 27,304.3 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ нь цахим удирдлагын системд орж, үнэлж, эрэмбэлэгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 3.9, 4.6, 5.2, 5.3, 5.8 дах заалтуудыг зөрчиж батлагджээ.

Аймгийн Засаг даргын саналд үндэслэгдэж батлагдсан 6 төсөл, арга хэмжээний 3 нь нийгмийн салбарын барилга, байгууламж, 3 нь шинээр хийгдэж буй бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажлууд байна.

Аймгийн ТЕЗ-аас хэрэгжүүлэхээр явуулсан төсөл, арга хэмжээний саналын судалгаа.

Хүснэгт 1

№	Хуулийн код	Төсвийн ерөнхийлөн захирагч	Аймгаас явуулсан санал		Жагсаалтаар батлагдсан арга хэмжээ		Саналд тусгагдаж жагсаалтаар батлагдсан		Саналд тусгагдаагүй жагсаалтаар батлагдсан	
			Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Тоо хэмжээ	Төсөвт өртөг
1	III	Монгол улсын ерөнхий сайд	2	755.5	1	600.0			1	600.0
2	IV	Шадар сайд	5	139.9						
3	V	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	3	5,400.0	1	400.0			1	400.0
4	VI	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	6	208.8	1	60.0			1	60.0
5	XI	Барилга, хот байгуулалтын сайд	7	23,731.6						
6	XIII	Боловсрол, шинжлэх ухааны сайд	11	12,260.9	8	8,157.9	2	2,033.6	6	6,124.3
7	XIV	Соёлын сайд	4	5,000.0	1	18,000.0			1	18,000.0
8	XV	Зам тээврийн хөгжлийн сайд	7	120,652.6	3	10,827.9	3	10,827.9		
9	XVII	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	3	2,300.0						
10	XVIII	Эрчим хүчний сайд	2	28,826.0	1	420.0			1	420.0
11	XIX	Эрүүл мэндийн сайд	23	7,047.5	2	3,400.0	1	1,700.0	1	1,700.0
			73	206,322.8	18	41,865.8	6	14,561.5	12	27,304.3

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын цахим мэдээллийн сан, 2021 оны Монгол Улсын төсвийн тухай хууль

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны “Эрэмбэлсэн дараалал батлах тухай” 41 дүгээр тогтоолоор сумдын нийгмийн салбарын барилга, байгууламж буюу сургуулийн хичээлийн байр, гал тогоо, дотуур байр, цэцэрлэг, соёлын төв, спорт заал, эмнэлгийн барилгууд болон сумдын ЗДТГ-ын конторын барилга шинээр барих, өргөтгөл, их засвар хийх эрэмбэ, дарааллыг баталжээ.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 11 ТЕЗ-дад хүргэгдсэн саналаас жагсаалтад батлагдсан эрүүл мэнд, боловсролын салбарын 3,733.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ нь аймгийн ИТХТ-ийн 41 дүгээр тогтоолын нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Тухайлбал:

- Угтаалцайдам сумын цэцэрлэгийн барилга 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,
- Хүмүүн цогцолбор сургуулийн хичээлийн А байрны их засвар 733.6 сая төгрөг төсөвт өртөгтэй,
- Баянцогт сумын ЭМТ-ийн барилга 1,700.0 сая төгрөг төсөвт өртөгтэй ажлууд байна.

ЗТХ-ийн сайдын багцад батлагдсан 3 хөрөнгө оруулалт буюу Эрдэнэсант сумын төвийн 3.2 км авто зам, Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам, Батсүмбэр сумын Мандалын голын төмөр бетон гүүрний шинэчлэлийн ажлууд аймгийн ТЕЗ-д саналд тусгагдан батлагджээ.

Шинээр хэрэгжихээр батлагдсан 41,865.8 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээнээс 20,110.9 сая төгрөгийн 13 ажил аймгийн ТЕЗ-д эрх шилжиж, 21,754.9 сая төгрөгийн 5 ажил эрх шилжээгүй байна.

2021 оны Монгол Улсын төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын судалгаа ТЕЗ-аар

Хүснэгт 2

№	Хуулийн код	Төсвийн ерөнхийлөн захирагч	Эрх шилжсэн ХО-ын ажил			Эрх шилжээгүй ХО-ын ажил		
			тоо	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	тоо	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт
1	III	Монгол улсын ерөнхий сайд				1	600.0	300.0
2	V	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	1	400.0	400.0			
3	VI	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	60.0	60.0			
4	XIII	Боловсрол, шинжлэх ухааны сайд	8	8,157.9	2,900.0			
5	XIV	Соёлын сайд				1	18,000.0	500.0
6	XV	Зам тээврийн хөгжлийн сайд	2	9,793.0	1,800.0	1	1,034.9	930.0
7	XVIII	Эрчим хүчний сайд				1	420.0	420.0
8	XIX	Эрүүл мэндийн сайд	1	1,700.0	500.0	1	1,700.0	500.0
		БҮГД	13	20,110.9	5,660.0	5	21,754.9	2,650.0

Эх сурвалж: ТЕЗ-ын тушаал, шийдвэр

А.2 Зөвлөх үйлчилгээ гэрээгээр гүйцэтгэгч компаниуд нь гэрээний хугацаанд ажлаа дуусгаж хүлээлгэж өгөөгүйгээс батлагдсан зураг, төсөвгүй барилга байгууламж баригдаж байна.

Аймгийн ТЕЗ-д эрх шилжин хэрэгжиж байгаа 13 ажлын 6 ажил нь их засвар, 7 нь шинээр баригдах барилга, байгууламж байна. Үүнээс 11 ажлын зураг, төсвийг зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж гүйцэтгүүлэн, МЭД-ээр баталгаажуулахаас шинээр баригдаж буй нэг барилга батлагдсан зураг төсөвгүй хэрэгжиж байна.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалт зардлын төрлөөр

Хүснэгт 3

№	Хуулийн код	Төсвийн ерөнхийлөн захирагч	Ихзасвар			Шинээр баригдах барилга, байгууламж		
			тоо	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	тоо	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт
2	V	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	1	400.0	400.0			
3	VI	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	60.0	60.0			
4	XII	Боловсрол, шинжлэх ухааны сайд	4	1,692.8	1,000.0	4	6,465.1	1,900.0
6	XV	Зам тээврийн хөгжлийн сайд				2	9,793.0	1,800.0
8	XX	Эрүүл мэндийн сайд				1	1,700.0	500.0
		БҮГД	6	2,152.8	1,460.0	7	17,958.1	4,200.0

Эх сурвалж: 2021 оны Төсвийн тухай хууль

Боловсролын болон Эрүүл мэндийн сайдын багцаас шинээр баригдах 5 барилга, байгууламж, их засварын 4 ажил, ЗТХ-ийн сайдын хоёр ажилд мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж,

Харин Баян-Өнжүүл сумын сургуулийн дээврийн засварын 50.0 сая төгрөгийн ажлын зураг, төсвийг захиалагч, БОАЖ-ын сайдын багцаас батлагдсан 60.0 сая төгрөгийн Манзушир хийд орчмын түүх, соёлын аялал жуулчлалын үзмэрийг сэргээх, тохижуулах ажил зураг, төсөвгүй аймгийн хэлтсийн мэргэжилтэн үнэлгээ, тооцоо гаргасан байна.

Шинээр хэрэгжих 3 ажлын зураг, төсөв боловсруулах зургийн даалгавар нь улсын төсөв батлагдсаны дараа буюу 2021 онд өгөгдсөн байна.

- Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/- 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,

- Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/- 2,865.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,

- Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/- 729.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,

Мөн 7 барилга, байгууламжид газрын зөвшөөрөл болон холбогдох техникийн нөхцөлүүд өмнө нь өгөгдсөн боловч Заамар сумын Хайлааст багийн 320 суудалтай сургуулийн барилга, Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам гэсэн 2 ажлын инженер геологийн дүгнэлтийг магадлалаар баталгаажуулж, үлдсэн таван ажил магадлалаар баталгаажуулж геологийн дүгнэлттэй байна.

Хөрөнгө оруулалтын 12 ажлаас 11 ажлын зураг, төсвийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 9 компани гүйцэтгэж, 50.0 сая төгрөгийн засварын нэг ажлын төсвийг захиалагч байгууллага гүйцэтгэжээ.

Зөвлөх үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэсэн гүйцэтгэгч нар нь гэрээний хугацаанд ажлаа хийж гүйцэтгээгүй, 1-7 сараар хугацаа хоцроосон байна. Тухайлбал:

- 4 ажил 1 сараар, 5 ажил 2-4 сараар, 1 ажил 7 сараар гэрээний хугацаа хэтрүүлж зураг, төсвөө баталгаажуулж, хүлээлгэн өгчээ. Харин 1 ажил тайлант он дуустал ажил нь хийгдээгүй, зураг төсвөө захиалагчид хүлээлгэж өгөөгүй байна.

Үүнд:

- Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварын ажлын зураг, төсвийг Тоонот констракшн ХХК нь 02 дугаар сарын 01-ээс 3 дугаар сарын 31 хүртэл хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Тус ажлын зураг, төсөв 2021 оны 10 дугаар сарын 26-нд МЕД-ээр баталгаажиж, 7 сараар хугацаа хэтэрч захиалагчид хүлээлгэн өгсөн байна.
- Заамар сумын Хайлааст багт баригдаж байгаа 320 суудалтай сургуулийн барилгын зураг, төсөв боловсруулах гэрээг ХБХДТ ХХК-тай 2021 оны 3 дугаар сарын 15-аас 6 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгүүлэхээр байгуулсан боловч тухайн онд МЕД нь гараагүй, 2022 оны 1 сард зөвхөн барилгын суурь, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын ажлын төсөв МЕД-ээр баталгаажжээ.

Зөвлөх үйлчилгээний нийт 375.5 сая төгрөгийн 11 гэрээг 9 компанитай байгуулж, 302.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон 72.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна. Үүнд:

- Заамар сумын Хайлааст багт баригдаж байгаа 320 суудалтай сургуулийн 58.0 сая төгрөгийн ХБХДТ ХХК-тай байгуулсан гэрээний үлдэгдэл санхүүжилт 40.0 сая төгрөг,
- Баянцогт сумын ЭМТ-ийн барилгын 27.8 сая төгрөгийн Өлзий-Иш ХХК-тай байгуулсан гэрээний үнэ,
- Эрдэнэсант сумын төвийн хатуу хучилттай 3.2 км авто замын 5.0 сая төгрөгийн Ар Си Эс Си ХХК-ий санхүүжилт байна.

Шинээр хэрэгжих 11 ажлын 4 ажлын зураг, төсөв өмнө хийгдэж МЕД-ээр баталгаажсанаас 3 ажлын төсвийг шинэчилсэн байна. Шинэчилсэн төсвөөр 2021 онд хийгдсэн 2 ажлын төсөвт өртөг нэмэгдэж, нэг ажлын төсөвт өртөг буурсан байна. Тухайлбал: Баянцогт сумын ЭМТ-ийн барилга 2018 онд 831.7 сая төгрөгөөс 1,376.8 сая төгрөг болж 545.1 сая төгрөгөөр буюу 66 хувиар, Баянжаргалан сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил 2015 онд 638.6 сая төгрөгөөс 780.2 сая төгрөг болж, 141.6 сая төгрөгөөр буюу 22 хувиар нэмэгдсэн бол Эрдэнэсант сумын авто замын ажил 2015 онд 1,756.7 сая төгрөгөөс 1,631.6 сая төгрөг болж 125.4 сая төгрөгөөр буурч баталгаажсан байна.

ТЕЗ-дын салбарын хэмжээнд батлагдсан засварын зардлаас санхүүжилт нь хуваарилагдаж ирсэн 50.0 сая төгрөгийн Баян-Өнжүүл сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын дээврийн их засвар, 60.0 сая төгрөгийн Манзушир хийд орчмын түүх, соёлын аялал жуулчлалын үзмэрийг сэргээх, тохижуулах ажил гэсэн 2 засварын ажлаас бусад 11 ажлын зураг, төсвийг магадлалын дүгнэлт гаргуулахаар БХТ-д шилжүүлжээ.

ЗТХ-ийн сайдын багцаас хэрэгжсэн Эрдэнэсант сумын төвийн хатуу хучилттай 3.2 км авто зам, Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам гэсэн хоёр ажлын МЕД хуулийн хугацаанд буюу төсвийн тухай хууль батлагдахаас өмнө баталгаажиж бусад есөн ажлын зураг, төсөв санхүүжилт батлагдсаны дараа буюу 2021 онд гэрээ хийгдэж, баталгаажсан байна.

А.3 Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалт нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны “Эрэмбэлсэн дараалал батлах тухай” 41 дүгээр тогтоолоор эрэмбэлэгдсэн дарааллын сүүлд эрэмбэлэгдсэн, эрэмбэд ороогүй, барилгын үнэлгээгээр 4-5 оноогоор үнэлэгдсэн боловч тухайн хөрөнгө оруулалтын ажлууд нийгмийн хэрэгцээ шаардлага болон барилгын ашиглалт, орон нутгийн хүн амын өсөлт, хөгжлөөс шалтгаалан зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлууд батлагджээ. /Хавсралт 1/

Харин 2020 оноос 2021 онуудад он дамжин хэрэгжсэн Соёлын сайдын багцын 1,200.0-2,000.0 сая төгрөгийн өртөгтэй соёл, спортын төвийн 4 барилгыг орон нутаг дах хүн амын тоо, суурьшил, нягтрал, газар зүйн байрлал, барилгын ашиглалт зэргээс шалтгаалан хэрэгцээ шаардлага бага буюу шаардлагагүй, хүчин чадал нь ихэдсэн гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал:

- Соёл, спортын төвийн барилга /Төв, Баянжаргалан сум/ нь 1,200.0 сая төгрөгийн өртөгтэй, сумын хүн ам цөөн, суурьшил муу, газар зүйн байрлалын хувьд улсын болон аймгийн хэмжээний тэмцээн уралдаан зохион байгуулахад тохиромжгүй алслагдмал,
- Соёл, спортын төвийн барилга /Төв, Сэргэлэн сум/ нь 1,200.0 сая төгрөгийн өртөгтэй, сумын хүн ам цөөн, суурьшил муу, газар зүйн байрлалын хувьд аймгийн төвөөс 7.0 км зайтай,
- Соёл, спортын төвийн барилга /Төв, Борнуур сум/ нь 2,000.0 сая төгрөгийн өртөгтэй, Соёлын төвийн барилга /Төв, Баянчандмань сум/ нь 1,500.0 сая төгрөгийн өртөгтэй бусад барилгууд нь сумдтай харьцуулахад хүн ам олон, суурин хүн ам ихтэй, газар зүйн байрлалын хувьд улсын чанартай зам дагуу боловч тус 2 сум нь хоорондоо 30.0 км-ын зайтай оршдогоос зэрэгцээ хоёр суманд сум тус бүрд соёл, спортын төвийн барилга баригдаж байна.

Соёл, спортын төвийн барилгууд




Баянжаргалан сум: Гүйцэтгэгч Их даян бүүвэй ХХК, ажлын гүйцэтгэл 25%



Борнуур сум: Гүйцэтгэгч Жоншт ХХК, ажлын гүйцэтгэл 66 %



Баянчандмань сум: Гүйцэтгэгч Мета менежмент ХХК, ажлын гүйцэтгэл 88%



Сэргэлэн сум: Гүйцэтгэгч Өгөөмөр уул ХХК, ажлын гүйцэтгэл 71%

2020 онд баригдаж эхэлсэн тухайн барилгууд 2021 оны жилийн эцсийн байдлаар ашиглалтад ороогүй, ажлын гүйцэтгэл 25-90 хүртэлх хувьтай байна.

Эрх шилжиж хэрэгжсэн 13 ажлаас 11 ажлын зураг, төсвийг зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн бөгөөд 1 ажлын зураг, төсвийг захиалагч гүйцэтгэж, нийт 12 ажлын зураг төсөв хийгдсэн байна. ЗТХ-ийн сайдын багцаас хэрэгжсэн 2 ажил зураг, төсөвтэй батлагдаж, бусад 10 ажлаас 6 ажлын зургийн даалгавар өмнө хийгдсэн боловч зураг, төсөв боловсруулах гэрээг “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль” батлагдсаны дараа гэрээ байгуулан техникийн нөхцөлүүд өгөгджээ. /3 ажлын төсөв шинэчлэгдсэн/.

Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдсанаас “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар батлагдсан төсөвт өртөг, МЭД-ээр баталгаажсан төсөвт өртгийн хооронд зөрүү гарчээ. 2021 оны төсвийн тухай хуульд 5 ажлын төсөвт өртөг бүгд 1,906.6 сая төгрөгөөр дутуу, 2 ажлын төсөвт өртөг бүгд 343.0 сая төгрөгөөр илүү тусгагдсан байна. Хуульд төсөвт өртөг дутуу тусгагдсанаас хөрөнгө оруулалтын зарим ажлуудын санхүүжилт дутуу батлагдах, гэрээт хугацаанд ашиглалтад орох боломжгүй, дутуу хэрэгжихээр болжээ. /Хавсралт 2/

Үүнд:

- 150 хүүхдийн суудалтай Угтаалцайдам цэцэрлэгийн барилга 878.2 сая төгрөгөөр, Лүн сумын цэцэрлэгийн барилга 871.9 сая төгрөгөөр төсөвт өртөг нь дутуу батлагдсанаас тухайн барилгын инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын ажил хийгдэх боломжгүй, барилга дутуу,

Угтаалцайдам, Лүн сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга



Угтаалцайдам сум: Гүйцэтгэгч Тэнгэрийн долоон од ХХК, гүйцэтгэл 39%



Лүн сум: Гүйцэтгэгч Төв цогт өлзийт ХХК, гүйцэтгэл 30%

- Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/-ын ажлын төсөвт өртөг 117.9 сая төгрөгөөр дутуу батлагдаж, хэрэгжсэн.

Архуст сумын ЗДТГ-ын их засвар



Архуст сум: Гүйцэтгэгч Виста групп ХХК, гүйцэтгэл 100%

Харин Баянцогт сумын ЭМТ-ийн барилгын хувьд төсөвт өртөг “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар 323.2 сая төгрөгөөр илүү батлагджээ.

Үүнээс гадна Төв, Заамар сум, Хайлааст багт 320 суудалтай сургуулийн барилга, зураг төсөвгүй 2,865.1 сая төгрөг батлагдаж, зураг, төсөв боловсруулах гэрээг ХБХДТ ХХК-тай 2021 оны 3 дугаар сарын 15-аас 6 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэхээр байгуулсан боловч тухайн онд МЕД нь гараагүй, 2022 он 1 сард 2,124.8 сая төгрөгийн зөвхөн барилгын суурь, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын ажлын төсөв баталгаажжээ. Хуулиар батлагдсан төсөвт өртөг, МЕД-ээр баталгаажсан төсөвт өртгөөс 740.3 сая төгрөгөөр бага байгаа боловч тухайн барилгын ажлын нийт төсөвт өртөг бүрэн баталгаажиж гараагүй, барилга дутуу,

Заамар сумын Хайлааст багт баригдаж байгаа
320 суудалтай сургуулийн барилга



Тайлбар: Заамар сумын Хайлааст багт баригдаж байгаа 320 суудалтай сургуулийн барилга батлагдсан зураг төсөвгүй баригдаж байна.

“Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар 20,110.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ажилд 5,660.0 сая төгрөг буюу төсөвт өртгийн 28 хувьд санхүүжилт батлагджээ.

Тайлант онд 6 засварын ажлаас Архуст сумын ЗДТГ, Баянчандмань, Баян-Өнжүүл сумын сургуулийн дээврийн засвар, Манзушир хийд орчмын түүх, соёлын аялал жуулчлалын үзмэрийг сэргээх, тохижуулах гэсэн 690.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажил тухайн ондоо хэрэгжиж дуусахаар, санхүүжилт нь бүрэн батлагджээ. Харин 2 засварын ажил он дамжин хэрэгжихээр санхүүжилт нь 50 хувьтай батлагдсан байна.

“Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-д шинээр баригдах 7 хөрөнгө оруулалт буюу барилга, замын ажлууд он дамжин 2022 онд хэрэгжиж дуусахаар батлагдан, нийт төсөвт өртгийн 10-60 хувьд санхүүжилт батлагджээ. Санхүүжилтийн батлагдсан хувиас харахад Баянжаргалан сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл 63 хувь, Эрдэнэсант сумын төвийн хатуу хучилттай 3.2 км авто замын ажил 50 хувийн санхүүжилт батлагдаж, хуулийн хугацаанд буюу 2022 онд нийт 2 ажил хэрэгжиж дуусах боломжтой байна.

Харин үлдсэн 5 хөрөнгө оруулалтын ажлуудад төсөвт өртгийн 10-38 хувийн санхүүжилт баталснаас харахад зарим ажил хугацаандаа хэрэгжих боломжгүй харагдаж байна. Тухайлбал: Заамар сумын Хайлааст багийн 320 суудалтай сургуулийн барилга 17 хувь, Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто замын ажлын санхүүжилт 12 хувьтай батлагджээ.

А.4 Батлагдсан зураг, төсөвгүй ажлыг ажлын тоо хэмжээгээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж, үнэлгээний хороо нь ТББ-ийн шалгуур хангаагүй оролцогчид гэрээ байгуулах эрх олгожээ.

Үнэлгээний хорооны гишүүд нь тендерт оролцогчийн шалгуурыг буруу тооцох, хуульд орсон өөрчлөлтийг мэдэхгүй байх, ТББ-ийг бүрэн хянаж шалгаагүйгээс зарим оролцогчийн эрхийг хязгаарлах, мөн хуулийн заалтыг буруу хэрэглэж шалгуур хангаагүй оролцогчид эрх олгох зэргээр тендерт оролцогчийн ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулаагүй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан байна. Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журмын 2.13-т “... эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, ... холбогдох албан тушаалтанд эрх шилжүүлсэн байх” гэж заасан боловч 8 ТЕЗ-аас эрх шилжсэн 13 хөрөнгө оруулалтын ажлаас ЗГХЭГ-аас эрх шилжсэн 1 ажил, БШУ-ын сайдын багцаас 1 засварын ажлаас бусад 11 ажил хуулийн хугацааг 16-41 хоногоор хэтрүүлж эрх шилжүүлжээ. Тухайлбал: БОАЖ-ын сайдын багцаас эрх шилжсэн 1 ажил 16 хоног, БШУ-ы сайдын багцын 8 ажлын 7 ажил, ЭМС-ын багцын 1 ажил 41 хоногоор буюу 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8-д заасан хугацааг хэтрүүлж эрх шилжиж ирсэн байна.

ТЕЗ-чдаас эрх шилжиж ирсэн хамгийн сүүлийн хугацаа 02 сарын 25-ны өдөр бөгөөд аймгийн Засаг дарга 2021 оны 3 сарын 18-ны өдөр буюу 20 хоногийн дараа улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөө баталж, захиалагчийг томилжээ. ХАА-ны төлөвлөгөөгөөр 3 сарын 25-ны өдөр үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөж, төлөвлөсөн хугацаанд үнэлгээний хороог байгуулжээ. Үнэлгээний хороо нь 13 ажлын ХАА зохион байгуулснаас 5 ажлын ХАА анхны тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, найман ажлын ХАА-г 2-4 удаа зохион байгуулжээ.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хорооны гаргасан шийдвэрт зарим тендер оролцогчоос гомдол гарах, батлагдсан зураг, төсөвгүй ажилд тендер зарласнаас оролцогч оролцохгүй байх, оролцогчдоос шалгуур хангасан компани байхгүй гэх зэргээс шалтгаалан гүйцэтгэгч сонгон шалгаруулах хугацаа хойшилж, гэрээ байгуулагдсан байна.

ХАА хугацаа алдсан шалтгаан:

-Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэрт гурван ажлын оролцогчоос дөрвөн удаа Сангийн яаманд гомдол гаргаж, үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж, нэг ажлын дүгнэлтийг хэвээр үлдээж, 2 ажлын тендерийг дахин зарласан. Үүнд: Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/-ын тендер 4 удаа, Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/-той ажлын тендер дөрвөн удаа зохион байгуулагдаж, 2 удаа гомдол гарснаас тайлант хугацаанд 2 ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажил гүйцэтгэх хугацаагүй болсон байна.

-Батлагдсан зураг, төсөвгүй ажилд ажлын тоо хэмжээгээр ХАА зохион байгуулснаас дахин тендер зарлагдсан. Үүнд:

- Хийгдэх ажил тодорхойгүй: Манзушир хийд орчмын түүх, соёлын аялал жуулчлалын үзмэрийг сэргээх, тохижуулах ажлын тендер 3 удаа зохион байгуулагдсан,
- Зарлагдсан төсөвт багтах боломжгүй: Архуст сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлын ХАА дөрвөн удаа, Хичээлийн А байрын барилгын их засвар /Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургууль/, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/ тус бүр 2 удаа зохион байгуулагдсан,
- Ажлын тоо хэмжээнээс илүү өндөр төсөвтэй ХАА зохион байгуулсан: Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/-той ажлын тендер дөрвөн удаа зохион байгуулагдаж, 2 удаа гомдол гарсан.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь тендерийн жишиг баримт бичгийг журмын дагуу бэлтгэж, ХАА-г зохион байгуулсан боловч ТББ-ийн ТООЗ-д заасан шалгуурыг хангаагүй оролцогчийг шалгаруулж гэрээ байгуулжээ.

Тухайлбал:

- ТООЗ-ийн 14.1-д “ажлын зураг, төсвийн дагуу тооцсон төсөв зохиож, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна” гэсэн боловч ЗТХ-ийн сайдын 2 ажлаас бусад ажил нь баталгаажсан зураг, төсөвгүй ажилд ажлын тоо хэмжээгээр тендер зарласан байна. Үүнээс шалтгаалан үнэлгээний хороо буруу шийдвэр гаргах, оролцогчоос гомдол гарах зэрэг зөрчил гарчээ. Үүнд: Баянцогт сумын эрүүл мэндийн төвийн барилгын тендерийн урилгад төсөвт өртөг 1,700.0 сая төгрөгөөр зарлагдсан. Эхний тендер шалгаруулалтаар 11 компани оролцож, гэрээ байгуулах эрх олгосон боловч гомдол гарч, гомдол нь үндэслэлтэй байсан тул дахин үнэлгээ хийхээр болсон боловч тендерийн хүчинтэй хугацаа дуусаж тендерийг дахин зарласан. 2 дах тендер шалгаруулалтын нээлтийн үеэр магадлалын дүгнэлт гарч 1,376.9 сая төгрөгийн төсөвт өртөг батлагдсан байна. 2 дах тендер шалгаруулалтад 6 оролцогч оролцсон боловч үнэлгээний хороо захиалагч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас төсөвт өртгийг буруу зарласан, батлагдсан төсвөөр 2 дах тендерийг зарлах боломжтой байтал төсөвт өөрчлөлт оруулаагүй, зарласан гэдэг шалтгаанаар тендерийг хүчингүй болгох шийдвэр гаргасан байна. 3 дах тендер шалгаруулалтыг 10 дугаар сарын 7-нд зарласан боловч тендерийн урилгад төсөвт өртгийг 1.7 тэрбумаар дахин зарлаж, ТШӨХ-д магадлалаар баталгаажсан төсөвт өртгийг оруулсан байна.
- ТББ-ийн ТООЗ 4.2.2-т “Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна”, ТООЗ 4.2.4-т “ШШГ-ын тодорхойлолт, харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй талаарх тодорхойлолт ирүүлнэ. ТООЗ 4.2.4-д заасан шалгуурыг хангаагүй тендерээс татгалзана”, ТООЗ 5.2 /б/-д “Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онуудын зөвхөн аудитлагдсан тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ. Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайлан дээрх системд шивэгдэж баталгаажуулаагүй нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно” гэсэн боловч тус шалгуурын хэд хэдэн заалтыг хангаагүй Вистагрупп ХХК-тай Архуст сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгосон байна. Тус компани нь 2019, 2020 оны аудитлагдсан тайлан байхгүй, 26.3 сая төгрөгийн татварын өртэй, Голомт банканд 16.6 сая төгрөгийн зээлийн өртэй бөгөөд эвлэрлийн гэрээгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон, НДШ-ийн тайлан байхгүй байна.
- ТШӨХ-ийн 10-т “Захиалагчаас тендерт оролцогчдод хүргүүлсэн ажлын төсөв, тоо хэмжээг үндэслэн өөрийн ажлын төсөвт өртгийн тооцоолол, төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар боловсруулж, төсөв бодох эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ” гэсэн заалттай боловч Манзушир хийд орчмын түүх, соёлын аялал жуулчлалын үзмэрийг сэргээх, тохижуулах захиалагч нь БОАЖГ зураг төсөв байхгүй, техникийн тодорхойлолт байхгүй, мэргэжилтний хийсэн үнээр ХАА зохион байгуулсан, Захиалагч нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасны дагуу “Үнэлгээний хороо” байгуулахдаа 47.3.1, 47.6 дах заалтыг зөрчиж, ХАА-ны мэргэшлийн АЗ сертификатын хугацаа дууссан иргэний төлөөллийг хоёр хөрөнгө оруулалтын ажлын “Үнэлгээний хороо”-нд оруулж томилсон байна.

Мөн аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон захиалагч байгууллага БЗОСК ОНӨААТҮГ нь зураг, төсөв боловсруулах 7 ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг тендер шалгаруулалт зохион байгуулалгүй 5 компанитай шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсний 4 гэрээг 2 компанитай байгуулсан байна. Үүнд: ТГТ ХХК бүгд 98.2 сая төгрөгийн 2 гэрээ, Хан тэнхлэг ХХК нь бүгд 45.3 сая төгрөгийн 2 гэрээ байгуулсан байна.

Үнэлгээний хорооны гишүүд нь тендерт оролцогчийн шалгуурыг буруу тооцох, хуульд орсон өөрчлөлтийг мэдэхгүй байх, ТББ-ийг бүрэн хянаж шалгаагүйгээс зарим оролцогчийн эрхийг хязгаарлах, мөн хуулийн заалтыг буруу хэрэглэж шалгуур хангаагүй оролцогчид эрх олгох зэргээр тендерт оролцогчийн ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулаагүй байна.

Үүнд:

- ХАА-г 2 удаа зарлаж, шалгуур хангасан оролцогч байхгүй гэдэг шалтгаанаар үнэлгээний хороо захиалагчид ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.4 дэх заалтыг зөрчиж шууд гэрээ /хэлэлцээр/ хийх эрхийг олгож, гэрээ байгуулсан байна. Үүнд: Архуст сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажил, Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод/, Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/-той ажлын тендерүүд байна. Жишээлбэл: Архуст сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажилд 2 удаа нээлттэй тендер зохион байгуулж, амжилтгүй болсон тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 31.1.3, 34.2-т заасны дагуу хэлэлцээрт оролцох эрх бүхий этгээдийн нэрийг ирүүлэх утгатай “Үнэлгээний хорооны дүгнэлтийг захиалагч байгууллага болох БЗОСК ОНӨААТҮГ-т хүргүүлжээ. Гуравдах буюу эхний хэлэлцээрт Вистагрупп ХХК-ий үнийн санал төсөвт өртгийн 5 хувиас хэтэрсэн, Бунбах ХХК нь НДШ-ийг 10.5 хувиар тооцсон гэдэг шалтгаанаар хэлэлцээр хүчингүй болж дахин зарлажээ. 2 дах хэлэлцээрийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл байхгүй, хэлэлцээрт Танан цамхаг констракшн ХХК, Вистагрупп ХХК оролцжээ. Танан цамхаг констракшн ХХК-ий төсөв шаардлага хангаагүй гэдэг шалтгаанаар татгалзаж, Вистагруппт гэрээ байгуулах эрх олгожээ. Шалгарсан Вистагрупп ХХК-ий, ТББ байхгүй, 2019, 2020 оны аудитлагдсан тайлан байхгүй, чанарын баталгааны мэдэгдэл гаргаж ирүүлээгүй, 26.3 сая төгрөгийн татварын өртэй, Голомт банканд 16.6 сая төгрөгийн зээлийн өртэй бөгөөд эвлэрлийн гэрээгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон, НДШ-ийн тайлан байхгүй байхад шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон байна.
- Үнэлгээний хорооны гишүүд нь оролцогчийн ТББ-тэй бүрэн танилцаагүй, алдаатай дүгнэлт гаргаж, оролцогчоос гаргасан гомдлын дагуу дахин үнэлгээ хийж өөрсдийн гаргасан шийдвэрээ буцаасан. Үүнд: Эрдэнэсант сумын 3.2 км автозамын ажлын ХАА 2 удаа зохион байгуулагдсан. Эхнийх оролцогчгүй, 2 дахид Ноблероуд ХХК буюу 1 оролцогч оролцжээ. Үнэлгээний хороо нь “газартай танилцсан акт байхгүй, ижил төстэй ажлын гэрээ, акт ирүүлээгүй, шаардсан инженер техникийн ажилчдаас лаборант байхгүй” гэсэн хэд хэдэн шалтгаанаар тус компаниас татгалзсан байна. Оролцогчоос захиалагч БЗОСК-д ТББ бүрдлийг хангасан тухай гомдол гаргаж, үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж, гомдол үндэслэлтэй байх тул тухайн замын ажил нь 3 жил болсон, хучилтын ажлыг яаралтай хийх шаардлагатай тул гэрээ байгуулахаар болсон байна. Мөн Баянцогт сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажилд эхний тендер шалгаруулалтаар 11 компани оролцож,

Арбулаг ХХК, Хабул констракшн гэсэн 2 компани шаардлага хангасан гэж үзэж бага үнийн аргаар Арбулаг ХХК-ийг шалгаруулжээ. Хабул констракшн ХХК Сангийн яаманд гомдол гаргаж, дахин үнэлгээ хийж Хабул констракшн ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон боловч Ар булаг ХХК гомдол гаргаж, гомдол нь үндэслэлтэй байсан тул дахин үнэлгээ хийхээр болсон боловч тендерийн хүчинтэй хугацаа дуусаж тендерийг дахин зарласан.

- Үнэлгээний хорооны гишүүд нь хуулийн мэдлэггүй, хууль, журамд орсон өөрчлөлтийг сайн судалж мэдээгүйгээс шалтгаалж, алдаатай дүгнэлт гаргажээ. Үүнд: Эрдэнэсант сумын 3.2 км автозамын ажлын ХАА 2 удаа зохион байгуулагдсан. Эхнийх оролцогчгүй, 2 дахид Ноблероуд ХХК буюу 1 оролцогч оролцжээ. Үнэлгээний хороо нь "сүүлийн 3 жилийн тайлан ирүүлэхээс 2018 оны санхүүгийн аудитлагдсан тайлан ирүүлээгүй" гэжээ. Оролцогчоос захиалагч БЗОСК-д "2018 оны тайлангийн хувьд 2018 онд борлуулалтын орлогогүй тул Сангийн сайдын 2016 оны 41 дүгээр тушаалын 3.4.1, 3.4.2 гэсэн заалтын дагуу заавал аудит хийлгэх шаардлагатай аж ахуйн нэгж биш гэсэн гомдол гаргаж, үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж, сүүлийн 3 жилийн тайлан ирүүлэхээс сүүлийн 2 жилийн хувьд борлуулалттай ашигтай, ажилласан байгаа тул тухайн замын ажил эхлээд 3 жил болж, хучилтын ажлыг яаралтай хийх шаардлагатай учраас гэрээ байгуулахаар болсон байна.
- Монгол Улсын 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн "Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хууль, УНДЕГ-ын 2021 оны 6 сарын 30-ны өдрийн "Зөвлөмж хүргүүлэх тухай" 1/1077 тоот албан бичигт заасны дагуу НДШ-ийн 14.5 хувиас 13.5 хувь болгож 2021 оны 7 сарын 1-ээс хэрэгжүүлж эхэлсэн. Гэвч НДШ-ийг 13.5 хувиар тооцож ирүүлсэн оролцогчийг шалгуур хангаагүйд тооцож, 14.5 хувиар тооцсон оролцогчийг шалгаруулжээ. Тухайлбал:

-Баянцогт сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажилд эхний тендер шалгаруулалтаар 11 компани оролцож, эхний тендер шалгаруулалтаар Голден прогресс ХХК НДШ 13.5 хувиар тооцсон гэсэн ганцхан шалтгаанаар хасагдсан байна. /НДШ нь 2021 оны 7 сарын 01-нээс 14.5 хувь нь 13.5 хувь болсон байна./ 2 дах тендер шалгаруулалтын нээлтийн үеэр 2021 оны 6 сарын 2-нд магадлалын дүгнэлт гарч 1,376.9 сая төгрөгийн төсөвт өртөг батлагдсан байна. 2 дах тендер шалгаруулалтад 6 оролцогч оролцсон боловч үнэлгээний хороо захиалагч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас төсөвт өртгийг буруу зарласан, батлагдсан төсвөөр 2 дах тендерийг зарлах боломжтой байтал төсөвт өөрчлөлт оруулаагүй, зарласан гэдэг шалтгаанаар тендерийг хүчингүй болгох шийдвэр гаргасан байна. 3 дах тендер шалгаруулалтыг 10 дугаар сарын 7-нд зарласан боловч тендерийн урилгад төсөвт өртгийг 1.7 тэрбумаар дахин зарлаж, ТШӨХ-д магадлалаар баталгаажсан төсөвт өртгийг оруулсан байна. 3 дах тендер шалгаруулалтад 4 компани оролцсон боловч 1 компани тендерийн баталгаа ирүүлээгүй, 3 компани НДШ-ийг 14.5 хувиар тооцсон гэдэг шалтгаанаар шаардлага хангасан оролцогч байхгүй тул шууд гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох эрх бүхий этгээдийн нэрийг ирүүлэх тухай албан бичгийг захиалагчид хүргүүлэхээр шийдвэрлэжээ.

-Баянчандмань сумын сургуулийн дээвэр засвар 8 оролцогчтой, 6.22-нд гэрээ байгуулах эрх олгосон. Зуун сод хийц 175.1 сая төгрөг /2/, НДШ-13.5 хувь, Эй уан констракшн дизайн ХХК 167.5 /7/, НДШ-13.5 хувь, шалгарсан Хустайн шил ХХК нь 14.5 хувиар бодсон.

-Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/ Эхний 3 оролцогч шаардлага хангаагүй, 2 дах шалгаруулалтаар 2 оролцогчтой шалгарсан Тэнгэрийн долоон од ХХК НДШ 14.5 хувь, 36 сар баталгаа гаргасан,

- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Төв, Баянжаргалан сум/ шалгарсан Халзан хайрхан НДШ 14.5 хувь,
- Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/-Алегротовер констракшн ХХК- 2,859.9 сая төгрөг, НДШ 14.5 хувиар тооцож шалгарсан, Голденпрогресс ХХК-2,777.7 сая төгрөг ТООЗ-14.1 /ж/ 36 сарын баталгаа гаргасан шалтгаанаар хасагдсан.
- Архуст сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажилд Бунбах ХХК нь НДШ-ийг 10.5 хувиар тооцсон, Баянцогт сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажилд эхний тендер шалгаруулалтаар 11 компани оролцож, эхний тендер шалгаруулалтаар Голден прогресс ХХК НДШ 13.5 хувиар тооцсон, /НДШ нь 2021 оны 7 дугаар сарын 01-ээс 14.5 хувь нь 13.5 хувь болсон байна/ гэсэн шалтгаанаар хасагдсан байна.

Б. “Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар зураг, төсөвгүй ажил батлагдаж хэрэгжсэнээс зарим ажлын санхүүжилт дутуу батлагдаж, хуулийн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй болжээ.

Б.1 Батлагдсан зураг, төсөвгүй ажилд ХАА зохион байгуулж, гэрээ байгуулснаар зарим барилга, хөрөнгө оруулалт дутуу хийгдэж, хуулийн хугацаанд ашиглалтад орох боломжгүй болсон байна.

“Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар аймагт эрх шилжиж хэрэгжсэн нийт 69,092.8 сая төгрөгийн 31 хөрөнгө оруулалтын ажил байна. Үүнд:

- Он дамжин хэрэгжих 48,981.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 хөрөнгө оруулалт,

- 2021 онд шинээр хэрэгжих 20,110.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 хөрөнгө оруулалтын ажил батлагдаж хэрэгжжээ.

Гэвч аудитын явцад эрх шилжиж хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт дах зарим ажил өөрчлөгдөж хуулиар батлагдсан шилжих болон шинээр хэрэгжих ажлын жагсаалтын тоо хэмжээ болон төсөвт өртөг зөрүү гарч байна. Тухайлбал: шинээр хэрэгжих ажлын жагсаалтад 1,741.3 сая төгрөгийн 3 ажил нэмэгдэж, он дамжин хэрэгжих ажлаас 1,631.3 сая төгрөгийн өртөгтэй 1 ажил хасагдсан байна. Үүнд:

-Шилжих барилгын жагсаалтад батлагдсан 1,631.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэсант сумын төвийн 3.2 км авто зам нь өмнө 550.0 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, замын суурийн ажил хийгдэж, комиссын актаар хүлээж авсан тул шинээр хэрэгжих,

-Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтад 2 сайдын салбарын хэмжээний засварын ажлын багцаас 110.0 сая төгрөгийн 2 засварын ажил нэмэгдэж батлагдан, нийт шинээр хэрэгжих 20,110.9 сая төгрөгийн өртөгтэй 13 ажил болсон.

Төв аймагт 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын судалгаа
Хүснэгт 4

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

№	Хуулийн код	ТӨЗ-ийн нэр	Ажлын тоо	Хуулиар батлагдсан		Байгуулсан гэрээ		Хэрэгжсэн	
				Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Ажлын тоо	Гэрээний дүн	Ажлын тоо	Гэрээний дүн
ШИЛЖИХ									
1	XII	БШУ-ны сайд	9	20,732.1	10,771.7	9	19,823.4	5	4,257.3
2	XIV	Соёлын сайд	4	5,900.0	4,740.0	4	5,861.7		
3	XIX	Эрүүл мэндийн сайд	2	2,044.6	1,794.6	2	2,038.9	1	1,297.9
4	XV	ЗТХ-ийн сайд	2	19,616.8	5,195.6	2	16,785.5	2	16,785.5
5	XI	БХБ-ын сайд	1	688.4	50.0	1	258.9		
			18	48,981.9	22,551.9	18	44,768.4	8	22,340.7
ШИНЭЭР									
1	V	ЗГХЭГ-ын дарга	1	400.0	400.0	1	400.0	1	400.0
2	XII	БШУ-ны сайд	8	8,157.9	2,900.0	8	7,846.7	2	219.9
3	XV	ЗТХ-ийн сайд	2	9,793.0	1,800.0	1	1,078.5	1	1,078.5
4	XIX	ЭМ-ийн сайд	1	1,700.0	500.0	1	1,320.3		
5	XIV	БОАЖ-ын сайд	1	60.0	60.0	1	59.9	1	59.9
			13	20,110.9	5,660.0	12	10,705.4	5	1,758.3
		НИЙТ ДҮН	31	69,092.8	28,211.9	30	55,473.8	13	24,099.0

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

2021 онд аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 69,092.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 ажлын 30 ажилд 55,473.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсанаас:

-2020 оноос 2021 он дамжин хэрэгжих 48,981.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ажилд 44,768.4 сая төгрөгийн гэрээ байгуулагджээ. Үүнээс 2020 онд БХБ-ын сайдын багцаас хэрэгжсэн Төв А33А ХХК-тай байгуулсан 258.9 сая төгрөгийн гэрээтэй Зуунмод сумын 5 багийн үерийн ус зайлуулах байгууламжийн ажил 34 хувийн гүйцэтгэлтэй 87.9 сая төгрөгийн санхүүжилт авч дараа онд буюу 2021 онд хэрэгжихээр төсвийн тухай хуулиар 50.0 сая төгрөг батлагдсан боловч аймагт эрх шилжиж ирээгүй байна.

-2021 онд эрх шилжин шинээр хэрэгжих 20,110.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ажлаас 12 ажилд 10,705.4 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 8,161.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто замын ажил тайлант хугацаанд гэрээ байгуулагдаагүй байна.

Зураг, төсөвгүй батлагдсан 11 ажлын 2 ажил буюу 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баян-Өнжүүл сумын сургуулийн дээврийн засварын ажил нь захиалагчаас гүйцэтгэсэн зураг, төсөвтэй, 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Манзуширын хийдийн тохижилтын ажил нь хэлтсийн мэргэжилтний хийсэн тооцоогоор ХАА зохион байгуулагдаж, гэрээ хийжээ.

Харин үлдсэн 9 ажлын зураг, төсвийг хийлгэхээр зөвлөх үйлчилгээний гэрээг тухайн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулагдахаас өмнө байгуулсан боловч ХАА батлагдсан зураг төсөвгүй зохион байгуулагджээ. Тухайлбал:

- Нэг барилгын ажлын төсөв шинэчлэх, гурван их засварын ажлын зураг, төсөв тендер зарлагдсаны дараа буюу тендер шалгаруулалтын явцад баталгаажсан байна. Үүнд: Баянцогт сумын ЭМТ-ийн барилгын шинэчилсэн төсөв, Архуст сумын ЗДТГ-ын их засвар, Хүмүүн сургуулийн А байрны их засвар, Баянчандмань сумын сургуулийн дээврийн их засварын ажлууд,

-Гурван барилгын ажил, нэг их засварын ажлын зураг, төсөв ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсанаас хойш 3 сарын дараа баталгаажсан, Үүнд: Угтаал, Лүн, Баянжаргалан сумын цэцэрлэгийн барилга, Аргалант сумын сургуулийн их засвар,

-Нэг ажил батлагдсан зураг, төсөвгүй хэрэгжсэн. Үүнд: Заамар сумын Хайлааст багийн 320 хүүхдийн сургуулийн барилга,

Батлагдсан зураг, төсөвгүй дээрх 9 ажлаас 7 ажлын ХАА-ны явцад хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаах зорилгоор ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж, тодруулга хийгдсэн байна. Тухайлбал: Баянжаргалан сумын цэцэрлэгийн өргөтгөлийн ажил, Баянчандмань сумын сургуулийн дээврийн их засварын ажлаас бусад 7 ажил,

2021 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжсэн ХО-ын зураг, төсвийн судалгаа

Хүснэгт 5

№	Хуулийн код	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсвийн тухай хуулиар			Үүнээс			
			тоо	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	тоо	Зураг, төсөвгүй	тоо	Батлагдсан зураг, төсөвтэй
2	V	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	1	400.0	400.0	1	400.0		
3	VI	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	60.0	60.0	1	60.0		
4	XIII	Боловсрол, шинжлэх ухааны сайд	8	8,157.9	2,900.0	8	8,157.9		
6	XV	Зам тээврийн хөгжлийн сайд	2	9,793.0	1,800.0			2	9,793.0
8	XIX	Эрүүл мэндийн сайд	1	1,700.0	500.0	1	1,700.0		
		БҮГД	13	20,110.9	5,660.0	11	10,317.9	2	9,793.0

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Тайлант хугацаанд буюу 2021 онд 36,632.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 хөрөнгө оруулалтын ажил ашиглалтад орохоор батлагджээ. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл нь:

-Он дамжин хэрэгжих 48,981.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 хөрөнгө оруулалтын ажлаас 13,039.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хан-уул, Алтанбулагийн авто замаас бусад 17 ажил 2021 онд хэрэгжиж дуусахаар батлагдсан боловч 8 ажил хэрэгжиж, ажлын гүйцэтгэл 47 хувьтай,

-Шинээр хэрэгжсэн 20,110.9 сая төгрөгийн 13 хөрөнгө оруулалтын ажлаас 19,420.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил 2022 он дамжин хэрэгжиж, 690.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажил тайлант хугацаанд хэрэгжихээр батлагдсанаас 5 ажил ашиглалтад оржээ.

Аймгийн хэмжээнд 69,092.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 ажилд 55,473.8 сая төгрөгийн 30 ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, тайлант хугацаанд 36,632.0 сая төгрөгийн 21 ажил хэрэгжиж дуусахаас 24,099.0 сая төгрөгийн 13 хөрөнгө оруулалтын ажил ашиглалтад орж, ажлын гүйцэтгэл дунджаар 62 хувьтай байна.

Ажлын гүйцэтгэлээр ЗТХ-ийн сайдын багцад батлагдсан 2022 он дамжин хэрэгжих Хан-уул, Алтанбулаг сумын авто зам, Эрдэнэсант сумын 3.2 км авто замын ажил хугацаанаас өмнө ашиглалтад орж, Соёлын сайдын багцад батлагдсан соёл, спортын төвийн 4 барилга, Эрүүл мэндийн сайдын багцын 1 барилга, БШУ-ы сайдын багцын 4 барилга хуулийн хугацаа хэтэрч, БХБ-ын сайдын багцын 1 ажил гэрээ байгуулагдаж, ажлын гүйцэтгэл дутуу он дамжсан боловч дараа жил эрх шилжиж ирээгүй байна.

Хөрөнгө оруулалтын ажлууд нь дараах шалтгаануудаар ашиглалтад ороогүй байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг гэрээт хугацаанд ашиглалтад орохоор тооцож баталдаггүй, олон хувааж, жил дамнуулан баталдгаас өндөр өртөгтэй барилгын ажлууд олон жил үргэлжилж, гэрээний хугацаанд ашиглалтад орох боломжгүй болж, гэрээний хугацаа хойшилдог байна. Энэ нь барилгын төсөвт өртөг нэмэгдэх, барилгын чанар муудах зэрэг эрсдэлтэй болж байна. 2019 оноос 2020 онд баригдаж, ашиглалтад орох гэрээ байгуулагдсан 2 барилга санхүүжилтээс шалтгаалан гэрээний хугацаанд ашиглалтад орох боломжгүй болсон байна. Үүнд: Батсүмбэр сумын 920 хүүхдийн сургуулийн барилгыг 2019 оны 9 сараас 2020 оны 12 сард ашиглалтад оруулах 8,313.0 сая төгрөгийн гэрээг Клаймакс ХХК байгуулжээ. Гэвч тус барилгын санхүүжилтэд 2019 онд 1,100.0 сая төгрөг, 2020 онд 2,807.8 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 47 хувь нь батлагджээ. 2021 онд 5,079.7 сая төгрөг, нийт 8,987.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан боловч цар тахлаас шалтгаалан хойшилсон. Зуунмод сумын 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургууль нь мөн 2019 оны 8 сараас 2020 оны 12 сард ашиглалтад оруулах 4,855.2 сая төгрөгийн гэрээг Эл Си Би ХХК байгуулжээ. Тус барилгын санхүүжилтэд 2019 онд 2,000.0 сая төгрөг, 2020 онд 1,502.6 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 72 хувь нь батлагджээ. 2021 онд үлдэгдэл санхүүжилтэд 1,500.0 сая төгрөг, нийт 5,002.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан боловч цар тахлаас шалтгаалан хойшилсноос гадна барилгыг 2019 онд байгуулсан гэрээний үнээр гүйцэтгэх боломжгүй, барилгын материал болон цалингийн зардал өссөн байна.
- Цар тахалтай холбоотойгоор үүссэн барилгын материалын хомсдол, үнийн хөөргөдлөөс шалтгаалж, барилгын ажил зогсонги байдалд орсон байна. Үүнд: Соёлын сайдын багцад батлагдсан 2020 оноос 2021 онд шинээр ашиглалтад орох 4 соёл, спортын төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт 2021 онд бүрэн батлагдсан боловч барилга, сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Төв, Заамар сум/ нь ашиглалтад ороогүй байна.
- Батлагдсан зураг, төсөвгүй ажилд ХАА зохион байгуулж, гэрээ байгуулснаар зарим барилга, хөрөнгө оруулалт дутуу хийгдэж, хуулийн хугацаанд ашиглалтад орох боломжгүй болсон байна. Жишээлбэл:

Угтаалцайдам, Лүн сумын цэцэрлэгийн барилга нь инженерийн холболтгүй, Заамар сумын Хайлааст багийн 320 хүүхдийн сургуулийн барилга батлагдсан төсөвт багтаан сургуулийн барилгыг ашиглалтад оруулахаар гэрээ байгуулагдсан боловч зураг, төсөв нь батлагдаагүй, зөвхөн суурийн ажил хийгдсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар БЗОСК ОНӨААТҮГ нь улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын захиалагчаар томилогджээ.

БЗОСК ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХТ-ийн 2017 оны 121 дүгээр тогтоолоор байгуулжээ. “Үйлдвэрийн газрыг өргөтгөж, дүрэм батлах тухай” тус тогтоолд “аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн орон тоо нь бүтээн байгуулалт, барилгын ажлын төсөв, санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах, зураг төсөв, техникийн норм дүрмийг дагаж мөрдүүлэх болон далдлагдах ажлыг шалгаж баталгаажуулах, барилга байгууламжийн ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх, барилга байгууламжийг чанартайгаар ашиглалтад оруулах ажлуудыг шаардлагын хэмжээнд хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна. Эдгээр дутагдлыг засаж, ажил сайжруулах зорилгоор аймгийн барилга захиалагчийн ажлын албыг шинээр байгуулан “Төв аймгийн Орон сууц корпораци” ОНӨААТҮГ-т нэгтгэн “Төв аймгийн Барилга захиалагч, Орон сууц корпораци ОНӨААТҮГ” болгон өөрчлөн зохион байгуулсугай” гэжээ. БЗОСК ОНӨААТҮГ-ын дүрмийн 4.1.14-т “үйл ажиллагааны үндсэн чиглэл нь төслийн хэрэгжилтэд захиалагчийн болон техникийн хяналт хийх”, 6.1.6-д “үйлдвэрийн газрын санхүүжилт нь үйлдвэрийн газрын хэрэгжүүлэх тодорхой төслийг санхүүжүүлэхэд зориулан улс болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө” байна гэжээ. Мөн Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана” гэжээ.

Тайлант хугацаанд тус үйлдвэрийн газар нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн барилгын ажлын гүйцэтгэлд хяналтын хоёр инженертэйгээр ажиллажээ. Захиалагчаас улсын төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан 30 ажлаас Баянцогтын эрүүл мэндийн төвийн барилгын ажлаас бусад ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж, “захиалагчийн техникийн хяналтын тэмдэглэл” үйлдэж, гүйцэтгэгчээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан байна.

Гэвч БЗОСК ОНӨААТҮГ нь батлагдсан дүрмүүдийн дагуу санхүүжигддэггүй, захиалагчийн ажил үүргийг гүйцэтгэх инженерүүдийн орон тооны хувьд ГХБХБГ-ын хяналтын инженерийн орон тоогоор ажилладаг нь тухайн үйлдвэрийн газрыг байгуулах болсон зорилтыг хангахгүй байна.

Захиалагч нь зөвлөх үйлчилгээний гэрээгээр ажил гүйцэтгэсэн компаниудтай зохиогчийн хяналтын ажлын 315.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, 202.4 сая төгрөгийн санхүүжилтийг зохиогчийн хяналтын зардалд олгосон байна. Зохиогч нь “барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийсэн дүгнэлт” бичиж, “зураг төсөл зохиогчийн хяналтын зардлын гүйцэтгэлийн акт” бичиж, захиалагчаас баталгаажуулан санхүүжилт олгогджээ. Барилга, байгууламж ашиглалтад оруулах комиссын актаар хүлээж авч, ашиглалтад хүлээн авсан зарим хөрөнгө оруулалтын ажлын зохиогчийн хяналтын зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлэн, санхүүжилтийг олгосон байна. Үүнд: Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Төв, Мөнгөнморьт сум/- Инженер гоедизи ХХК 1.0 сая төгрөг, Цэцэрлэгийн барилга, 100 ор /Төв, Эрдэнэсант сум/- ТГТ ХХК 0.8 сая төгрөг, Дотуур байрын барилга, 50 ор /Төв,

Баянхангай сум/- Цэнхэр төхөм ХХК 2.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

Зарим батлагдсан зураг, төсөвгүй ажилд захиалагч болон зохиогч хяналт тавьж санхүүжилт авчээ. Тухайлбал: Цэцэрлэгийн барилга /Төв, Угтаалцайдам сум/- ТГТ ХХК, Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Лүн сум/- ТГТ ХХК, Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/- ХБХДТ ХХК, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/- Тоонот констракшн ХХК

Б.2 Улсын төсвөөс нийт 48,984.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 10 ажлын 4,828.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 44,121.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 30 хөрөнгө оруулалтын ажилд 55,473.8 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулагджээ. Эдгээр гэрээт ажлуудад бүгд 908.8 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал тооцогдсоноос 704.7 сая төгрөгөөр санхүүжилт олгосон байна.

Зам тээврийн яам нь замын ажлуудад хяналт тавьж, ЗТХ-ийн сайдын багцад батлагдсан 3 ажлын 286.3 сая төгрөгийг захиалагчийн хяналтын зардалд тооцохоос 283.2 сая төгрөгийг суутган тооцохдоо Ялгуусан ХХК-ий гүйцэтгэсэн Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Туул тосгоны хатуу хучилттай авто замын төгсгөлөөс Төв аймгийн Алтанбулаг сумын төв хүртэлх хатуу хучилттай авто зам, 13.7 км /Төв, Алтанбулаг сум/-ын ажлын захиалагчийн хяналтын зардалд 1.6 сая төгрөг илүү суутган тооцжээ.

2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтад хийсэн хяналтын зардлын судалгаа

Хүснэгт 6

№	Хуулийн код	ТЕЗ-ийн нэр	Байгуулсан гэрээ		Захиалагчийн хяналтын			Зохиогчийн хяналтын зардал		
			Ажлын тоо	Гэрээний дүн	Тооцсон	Санхүүжсэн	Зөрүү	Тооцсон	Санхүүжсэн	Зөрүү
ШИЛЖИХ										
1	XIII	БШУ-ны сайд	9	19,823.4	334.7	280.3	54.4	167.4	139.3	28.1
2	XIV	Соёлын сайд	4	5,861.7	92.6	59.5	33.1	46.3	24.8	21.5
3	XIX	Эрүүл мэндийн сайд	2	2,038.9	34.5	27.9	6.6	17.3	11.5	5.8
4	XV	ЗТХ-ийн сайд	2	16,785.5	269.2	270.4	(1.2)	3.8		3.8
5	XI	БХБ-ын сайд	1	258.9			-			-
			18	44,768.4	731.0	638.1	92.9	234.8	175.6	59.2
ШИНЭЭР										
1	V	ЗГХЭГ-ын дарга	1	400.0	6.3	6.3	-	3.1	3.1	-
2	XIII	БШУ-ны сайд	8	7,846.7	132.0	47.5	84.5	66.0	23.7	42.3
3	XV	ЗТХ-ийн сайд	1	1,078.5	17.1	12.8	4.3			-
4	XIX	ЭМ-ийн сайд	1	1,320.3	22.4	-	22.4	11.2		11.2
5	XIV	БОАЖ-ын сайд	1	59.9			-			-
			12	10,705.4	177.8	66.6	111.2	80.3	26.8	53.5
		НИЙТ ДҮН	30	65,473.8	908.8	704.7	204.1	315.1	202.4	112.7

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Тайлант хугацаанд аймгийн Төрийн сан дах техник хяналтын зардлын дансанд захиалагчийн хяналтын зардалд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 298.8 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 94.8 сая төгрөг, бүгд 393.6 сая төгрөг төвлөрч, 145.9 сая төгрөгийн санхүүжилтийг БЗОСК ОНӨААТҮГ-т шилжүүлсэн байна.

Тайлант онд аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 55,473.8 сая төгрөгийн 30 ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, хэрэгжсэн байна. Үүнд: Он дамжин хэрэгжих 44,768.4 сая төгрөгийн 18 хөрөнгө оруулалт, шинээр хэрэгжих 10,705.4 сая төгрөгийн 12 хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагджээ.

2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийг харьцуулсан судалгаа

Хүснэгт 7

№	Хуулийн код	ТЕЗ-ийн нэр	Байгуулсан гэрээ		Бүгд	Олгосон санхүүжилт			Ажлын гүйцэтгэл		Бүрэн хэрэгжсэн	
			Ажлын тоо	Гэрээний дүн		Гүйцэтгэгч	Үүнээс		Мөнгөн дүнгээр	Хувиар	Ажлын тоо	Гэрээний дүн
							Барьцаа дансанд	Мөнгөн дүн				
ШИЛЖИХ												
1	XII	БШУ-ны сайд	9	19,823.4	19,954.3	17,744.0	4	2,210.3	17,783.5	94.6	5	4,257.3
2	XIV	Соёлын сайд	4	5,861.7	5,858.8	3,756.1	4	2,102.7	3,764.9	64.0		
3	XIX	Эрүүл мэндийн сайд	2	2,038.9	1,651.9	1,636.6	1	15.3	1,651.9	74.0	1	1,297.9
4	XV	ЗТХ-ийн сайд	2	16,785.5	16,785.5	16,750.9			16,785.5	100.0	2	16,785.5
5	XI	БХБ-ын сайд	1	258.9	87.9	87.9			87.9	34.0		
			18	44,768.4	44,338.4	39,975.5	9	4,328.3	40,073.7	73.3	8	22,340.7
ШИНЭЭР												
1	V	ЗГХЭГ-ын дарга	1	400.0	400.0	400.0			400.0	100.0	1	400.0
2	XIII	БШУ-ны сайд	8	7,846.7	2,889.9	2,889.9			2,889.9	57.8	2	219.9
3	XV	ЗТХ-ийн сайд	1	1,078.5	795.8	795.8			1,078.5	100.0	1	1,078.5
4	XIX	ЭМ-ийн сайд	1	1,320.3	500.0		1	500.0				
5	XIV	БОАЖ-ын сайд	1	59.9	59.9	59.9			59.9	100.0	1	59.9
			12	10,705.4	4,645.6	4,145.6	1	500.0	4,428.3	71.6	5	1,758.3
		НИЙТ ДҮН	30	55,473.8	48,984.0	44,121.1	10	4,828.3	44,502.0	72.5	13	24,099.0

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Эдгээр ажлуудад нийт 48,984.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 10 ажлын 4,828.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 44,121.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ. Ажлын гүйцэтгэлээр нийт гэрээт ажлын 72.5 хувь буюу 44,502.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэж, гүйцэтгэгч нь 380.7 сая төгрөгөөр дутуу санхүүжилт авчээ.

Санхүүжилтийн зөрүү нь:

-ЗТХ-ийн сайдын багцаас 2021-2022 он дамжин хэрэгжих Сумын төвийн авто зам, 3.2 км /Төв, Эрдэнэсант сум/ ажил нь 2021 онд бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд 282.7 сая төгрөгийн санхүүжилт дараа онд батлагдсанаас,

-Ажлын гүйцэтгэлээр Баянхангай сумын 50 ортой дотуур байрын барилгын ажлын зураг, төсөв зохиогчийн хяналтын зардлын 2.6 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж тооцсон,

-Захиалагчаас гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн 95.4 сая төгрөгийн зөрүүнээс үүсжээ.

Санхүүжилттэй холбоотой үүссэн 95.4 сая төгрөгийн 4 төрлийн зөрчлийг дурдвал:

-Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Туул тосгоны хатуу хучилттай авто замын төгсгөлөөс Төв аймгийн Алтанбулаг сумын төв хүртэлх хатуу хучилттай авто зам, 13.7 км /Төв, Алтанбулаг сум/-ын ажлын захиалагчийн хяналтын зардалд 1.6 сая төгрөг илүү тооцож, гүйцэтгэгч дутуу санхүүжсэн,

-Захиалагчийн хяналтын зардлыг холбогдох данс руу шилжүүлээгүй 2 ажлын 10.0 сая төгрөг,

-ЗТХЯ-аас Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам, 7.0 км /Төв, Зуунмод сум/-ын зураг, төсвийн үнэ 35.0 сая төгрөг, замын гэрэлтүүлгийн захиалагчийн хяналтын зардлын зөрүү 1.6 сая төгрөг, бүгд 36.2 сая төгрөгийг Орон нутгийн холбогдох данс руу шилжүүлээгүйгээс,

-Хэрэгжиж дуусаагүй 7 хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэлээс 50.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгожээ.

2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн зөрчлийн судалгаа

Хүснэгт 8

№	Санхүүжилт зөрүү үүссэн шалтгаан	Ажлын тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт			Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл, мөнгөн дүн	Ажлын гүйцэтгэл %	Санхүүжилт илүү дутуу
				Бүгд	Гүйцэтгэгч	Барьцаа хөрөнгийн дансанд			
1	Санхүүжилт он дамжин хэрэгжих	1	1,078.5	795.8	795.8		1,078.5	100.0	(282.7)
2	Зураг, төсөө зохиогчийн хяналтын зардал дутуу санхүүжсэн	1	914.6	912.0	912.0		914.6	100.0	(2.6)
1	Захиалагчийн хяналтын зардал илүү санхүүжсэн	1	10,506.0	10,507.6	10,507.6		10,506.0	100.0	1.6
2	Захиалагчийн хяналтын зардал дутуу санхүүжсэн	2	2,145.2	2,135.2	2,135.2		2,145.2	100.0	(10.0)
3	Зураг, төсвийн үнэ	1	6,279.5	6,243.3	6,243.3		6,279.5	100.0	(36.2)
4	Гүйцэтгэлээс дутуу санхүүжсэн	7	19,800.1	19,522.5	16,455.7	3,066.8	16,506.5	78.9	(50.8)
		11	38,730.8	38,408.6	35,341.8	3,066.8	35,437.2	86.3	(95.4)

(380.7)

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Ажлын гүйцэтгэл болон санхүүжилттэй холбоотой зөрчлөөс гадна гэрээний үнийн дүн болон санхүүжилттэй холбоотой зөрчил илэрлээ. Тухайлбал: Батсүмбэр сумын 920 суудалтай сургуулийн барилгын ажилд 8,313.0 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан бөгөөд төсвийн тухай хуульд 8,987.5 сая төгрөг батлагдаж, 8,981.1 сая төгрөгөөр санхүүжилт олгож, гэрээний үнийн дүнгээс 668.1 сая төгрөгөөр илүү санхүүжилт хийгдсэн байна.

Б.3 Төв аймаг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ажлыг гэрээгээр гүйцэтгэгч нарт барьцаа хөрөнгө болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгоогүй, ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгосон байна.

Тайлант хугацаанд хэрэгжих 55,473.8 сая төгрөгийн 30 гэрээт ажлаас 54,973.8 сая төгрөгийн 29 гэрээт ажил хэрэгжиж санхүүжилт олгож, 500.0 сая төгрөгийн 1 ажлын гэрээ оны эцэст гэрээ байгуулагдан тухайн онд хэрэгжих боломжгүй болж санхүүжилт хийгдээгүй байна

Аймгийн ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд 10 ажлын 4,828.3 сая төгрөгийн санхүүжилтийг байршуулснаас он дамжин хэрэгжиж байгаа 9 ажлын 4,328.3 сая төгрөг, шинээр хэрэгжих 1 ажлын 500.0 сая төгрөгийн санхүүжилт байна.

Гэрээгээр ажил гүйцэтгэгч нарт барьцаа хөрөнгө болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгоогүй, ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгожээ.

2021 онд байнгын ашиглалтад орох комиссын актаар 24,099.0 сая төгрөгийн 13 хөрөнгө оруулалтыг хүлээн авч, ашиглалтад оруулсан байна. Эдгээр ажлаас 6,279.5 сая төгрөгийн Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай 7.0 км авто

замыг данс бүртгэлд тусгаагүй, бусад 17,819.5 сая төгрөгийн 12 хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, данс бүртгэл тусгасан байна.

Комиссын актаар хүлээн авч ашиглалтад орсноос 22,921.6 сая төгрөгийн 8 барилга, байгууламж, 1,177.4 сая төгрөгийн 5 засварын ажил байна. Шинээр ашиглалтад орсон 8 барилга, байгууламжид:

-17,864.0 сая төгрөгийн 3 авто зам,

-5,057.6 сая төгрөгийн 5 барилга нь:

- 1,614.6 сая төгрөгийн 40-50 ортой 2 дотуур байр,
- 1,100.0 сая төгрөгийн 160.0 суудалтай сургуулийн 1 барилга,
- 1,045.2 сая төгрөгийн 100 хүүхдийн цэцэрлэгийн 1 барилга,
- 1,297.9 сая төгрөгийн 10 ортой эмнэлгийн 1 барилга ашиглалтад орж

бүрэн хүчин чадлаар нь зориулалтын дагуу ашиглаж байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль”-аар 41,865.8 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжихээр жагсаалтаар батлагдсанаас 14,561.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын саналд үндэслэж, 27,304.3 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын цахим удирдлагын системд орж, үнэлж, эрэмбэлэгдээгүй байна.

2. Батлагдсан зураг, төсөвгүй ажил батлагдсанаас хуулиар батлагдсан төсөвт өртөг, МЕД-ээр баталгаажсан төсөвт өртгийн хооронд зөрүү гарч, зарим ажлын төсөвт өртөг дутуугаас хөрөнгө оруулалтын зарим ажлын санхүүжилт дутуу батлагдаж, гэрээт хугацаанд ашиглалтад орох боломжгүй, дутуу хэрэгжихээр болжээ.

3. Зөвлөх үйлчилгээ гэрээгээр гүйцэтгэдэг компаниуд нь гэрээний хугацаанд зураг, төсвийн ажлыг гүйцэтгээгүйгээс батлагдсан зураг, төсөвгүй барилга байгууламж баригдаж байна.

4. Худалдан авах ажиллагаа батлагдсан зураг, төсөвгүй ажлын тоо хэмжээгээр зохион байгуулагдсанаас оролцогчоос гомдол гарах, оролцогчгүй байх, шалгуур хангасан гүйцэтгэгч байхгүй гэх зэрэг шалтгаанаар тендер дахин зарлагдан зарим компанитай ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчиж, шууд гэрээ байгуулсан байна.

5. Үнэлгээний хорооны гишүүдийн хууль эрх зүйн мэдлэг дутуугаас тендер оролцогчийн эрхийг хязгаарлаж, шалгуур хангаагүй компаниудад гэрээ байгуулах эрх олгожээ.

6. Захиалагч нь зөвлөх үйлчилгээний гэрээг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй, шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлснээс гэрээний хугацаа хэтрэх, ямар нэгэн хариуцлага тооцох боломжгүй болсон байна.

7. Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг хуулийн хугацаа буюу гэрээний хугацаанд ашиглалтад орохоор тооцож баталдаггүй, олон хувааж, жил дамнуулан баталдаг, батлагдсан зураг, төсөвгүй ажилд гэрээ байгуулснаар зарим барилга, хөрөнгө оруулалт дутуу хэрэгжиж, гэрээний хугацаанд ашиглалтад орох боломжгүй болох, төсөвт өртөг өөрчлөгдөх зэрэг зөрчлүүд үүсдэг байна.

8. Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор байгуулагдсан БЗОСК ОНӨААТҮГ нь хууль, дүрмийн дагуу санхүүжилт олгодоггүйгээс орон тоо бүтэц хангалтгүй, үйл ажиллагааны хувьд хязгаарлагдмал, захиалагч байгууллагын үүргийг хангалттай хэмжээнд гүйцэтгэж чадахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, ХОХБТХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ нарт зөвлөх нь:

1.Батлагдсан зураг, төсөвтэй, “улсын хөрөнгө оруулалтын удирдлагын систем”-ээр эрэмбэлэгдэж, үнэлэгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг улсын төсөвт тусгуулж, батлуулах,

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, ХОХБТХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Ю.Бямбацогт, “БЗОСК” ОНӨААТҮГ-ийн захирал Ж.Баттөгс нарт зөвлөх нь:

2.БЗОСК ОНӨААТҮГ-ыг хууль, дүрмийн дагуу ажиллуулах, санхүүжүүлэх, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх, ИТХТ-ийн хурлаар батлагдсан дүрмийг мөрдөж ажиллах боломжгүй тохиолдолд дүрэмд өөрчлөлт оруулж, хэрэгжүүлж ажиллах,

3.Хөрөнгө оруулалтад олгох санхүүжилтийг захиалагч, гүйцэтгэгч нар тооцоо хийхээс гадна бусад холбогдох байгууллагууд /СТСХ, ХОХБХ/ нь хоорондоо тооцоо нийлж, санхүүжилтийн зөрүүг арилгах,

ОНӨГ-ын дарга Д.Батжаргал, “БЗОСК” ОНӨААТҮГ-ийн захирал Ж.Баттөгс нарт зөвлөх нь:

4.Батлагдсан зураг, төсөвтэй ажилд худалдан авах ажиллагаа зохион байгуулах,

5.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх, тендерийн шалгуур хангасан оролцогчтой гэрээ байгуулах, зөрчил гаргасан үнэлгээний хорооны гишүүдийг дахин томилж ажиллуулахгүй байх

5.ТБОНӨХБАУХАТ хуулийн 34 дүгээр зүйл “гэрээ шууд байгуулах арга”-ыг хуулийн дагуу зөв хэрэглэх,

6.Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт явуулж, гэрээ байгуулах,

7.Засаг даргын захирамжаар томилогдсон үнэлгээний хороонд АЗ сертификаттай хүмүүсийг томилох, ХАА зохион байгуулагдахаас өмнө тендер шалгаруулалттай холбоотой хууль, журмаар сургалт, зөвлөмж өгч, гишүүдийг нэгдсэн ойлголттой болгох зөвлөмж өгөх,

“БЗОСК” ОНӨААТҮГ-ийн захирал Ж.Баттөгсөд зөвлөх нь:

8.Гэрээт ажлуудыг гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх, хугацаа хэтэрсэн шалтгааныг судалж, зөрчлийг арилгах, хариуцлага тооцох зэрэг захиалагчийн үүргийг бүрэн хэрэгжүүлэх,

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Ц.Хишигжаргал

О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Аудитор

Ч.Загдсүрэн

Хавсралт 1

Шинээр батлагдсан хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлагын судалгаа

	Төсөл арга хэмжээний нэр	Хуулийн		Одоо ашиглаж байгаа барилгын				Тайлбар	Хэрэгцээ шаардлага байгаа эсэх		
		Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	Ашиглалтанд орсон он	Засвар хийгдсэн он	Эрэмбэлэгдсэн дараалал	Үнэлгээ				
V	ЗГХЭГ										
1	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/	400.0	400.0	1987	2014	17	4	Дээврийн хучилтын завсраар ус ордог	Тийм		
XII	Боловсрол, шинжлэх ухааны сайд										
2	Цэцэрлэгийн барилга /Төв, Угтаалцайдам сум/	1,300.0	500.0	1964			1	0	50 хүүхдийн, МХГ-ын дүгнэлт гарсан.	Тийм	
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Лун сум/	1,500.0	400.0	1983			17	4	75 хүүхдийн	Тийм	
4	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Төв, Баянжаргалан сум/	800.0	500.0	1989	2014	39		5	50 хүүхдийн	Тийм	
5	Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/	2,865.1	500.0						Сургуультай боловч, барилга нь хуучирсан.	Тийм	
6	Сургуулийн барилгын дээврийн их засвар /Төв, Баянчандмань сум/	180.0	180.0	2012				39	5		Тийм
7	Хичээлийн А байрын барилгын их засвар /Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургууль/	733.6	400.0	1987	2010	1			0	Дээвэр зассан	Тийм
8	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/	729.2	370.0	1980	2009	24			4	Дусаал гоождог, цууралт өгсөн	Тийм
9	Сургуулийн барилгын дээврийн их засвар /Төв, Баян-Өнжүүл сум/	50.0	50.0	2011				30	4	бохир засах	Тийм
XIX	Эрүүл мэндийн сайд										
10	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/	1,700.0	500.0	1952				1	1	Зориулалтын бус, муудсан	Тийм
11	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Төв, Эрдэнэ сум/	1700.0	500.0	2003				6	1	МХГ-ын дүгнэлт гарсан.	Тийм
XV	ЗТХ-ийн сайд										
12	Сумын төвийн авто зам 3.2 км /Төв, Эрдэнэсант сум/	1,081.3	800.0							Замын суурийг өмнө хийсэн байсан.	Тийм
13	Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/	8,161.7	1,000.0							Шинээр хийгдсэн бүтээн байгуулалт	Тийм
14	Мандалын голын төмөр бетон гүүрийн шинэчлэл /Төв, Батсүмбэр сум/	1034.9	930.0								Тийм
VI	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд										
15	Төв аймгийн Манзуширын хийд орчмын шашин, түүх, соёлын аялал жуулчлалын үзмэрийг сэргээх, тохижуулах	60.0	60.0								Тийм
III	Монгол улсын ерөнхий сайд										
16	Спорт заалын барилга /Төв, Жаргалант сум/	600.0	300.0							Заалтай боловч, барилга нь хуучирсан.	Тийм
XIV	Соёлын сайд										
17	Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори /Төв, Зуунмод сум/	18,000.0	500.0								
XVIII	Эрчим хүчний сайд										
18	Сумын төвийн 0.4 кВ-ын шугамын шинэчлэлт /Төв, Баянцагаан сум/	420.0	420.0								Тийм
		41,315.8	8,310.0								

Эх сурвалж: Аймгийн ИТХТ-ийн 2016 оны "Эрэмбэлсэн дараалал батлах тухай" 41 дүгээр тогтоол, Аудитын ажлын баримт

2021 оны Төсвийн тухай хууль, МЭД-ээр баталгаажсан төсөөт өртгийн зөрүү тооцсон судалгаа

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	2021 оны төсвийн тухай хуулиар		МЭД-ээр төсөөт өртөг	Төсөөт өртгийн зөрүү		Тайлбар
			Төсөөт өртөг	Тухайн онд санхүүжих дүн		Дутуу	Илүү	
А			3	4	31	33		37
ШИНЭЭР								
ЗГХЭГ-ын дарга								
1	V.1.2.5	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/	400.0	400.0	517.9	(117.9)		
БШУ-ны сайд								
2	XIII.1.1.218	Цэцэрлэгийн барилга /Төв, Угтаалцайдам сум/	1,300.0	500.0	2,178.2	(878.2)		
3	XIII.1.1.244	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Лун сум/	1,500.0	400.0	2,371.9	(871.9)		
4	XIII.1.1.245	Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум. Хайлааст баг/	2,865.1	500.0				МЭД гараагүй
5	XIII.1.1.269	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Төв, Баянжаргалан сум/	800.0	500.0	780.2		19.8	2015 оны төсвийг шинэчилсэн.
6	XIII.1.2.42	Сургуулийн барилгын дээврийн их засвар /Төв, Баянчандмань сум/	180.0	180.0	188.6	(8.6)		
7	XIII.1.2.43	Хичээлийн А байрн барилгын их засвар /Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургууль/	733.6	400.0	733.6			
8	XIII.1.2.44	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/	729.2	370.0	759.2	(30.0)		
9	XIII.3.1.2.34	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дээврийн их засвар /Төв, Баян-Өнжүүл сум/	50.0	50.0				
ЗТХ-ийн сайд								
10	XV.1.1.24	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.2 км /Төв, Эрдэнэсант сум/	1,631.3	800.0	1,631.3			
11	XV.1.1.62	Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/	8,161.7	1,000.0	8,161.7			
ЭМ-ийн сайд								
12	XIX.1.38	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/	1,700.0	500.0	1,376.8		323.2	2018 оны төсвийг шинэчилсэн.
БОАЖ-ын сайд								
13	VI.2.1	Манзушир хийд орчмын түүх, соёлын аялал жуулчлалын үзмэрийг сэргээх, тохижуулах	60.0	60.0				
ШИНЭЭР БҮГД			20,110.8	5,660.0	18,699.4	(1,906.6)	343.0	

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Холбогдох байгууллагын санал:




ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН ЛУДИТЫН ГАЗАРТ

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангын төсөлтэй танилцаа.

Тус тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж хамтран ажиллах болно.

ХӨГЖЛИЙН БОДДОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА *[Signature]* Д.САРАН-ЭРДЭНЭ



4192020859



ТӨВ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Төв аймаг, нийслэл Улаанбаатар
Хүн амын 100 мянган төгрөг

2022.06.12 № 154

Тайлбар № _____

Хариу хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд аудитаар өгөгдсөн зөвлөмж албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг ханган ажиллах болно. Нэмэлт санал тайлбар байхгүй.

ДАРГА

Д. БАТЖАРГАЛ

202204049

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70272287
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn